



**БАТЛАВ:ХАТАНБУЛАГ СУМЫН
ЗАСАГ ДАРГА С.ЭРДЭНЭБОЛД**

**ХАТАНБУЛАГ СУМЫН
ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗАР**

2020 оны 03 дугаар сарын 26 ний өдөр

**Төслийн нэр: “ЭМНЭЛЭГИЙН ТОНОГ ТӨХӨӨРӨМЖ” БАРАА НИЙЛҮҮЛЭХ
ТЕНДЕРИЙН БИЧИГ БАРИМТ**

Төслийн дугаар: ХБ-ОНО-2020/05

Хатанбулаг сум
2020 он

ҮНИЙН САНАЛЫН УРИЛГА

Тендер зарлах өдөр: 2020-04-08

Тендер шалгаруулалтын нэр: ”Эмнэлэгийн тоног төхөөрөмж”

Тендер шалгаруулалтын дугаар: ХБ-ОНО-2020/05

Хатанбулаг сумын Засаг даргын Тамгын газар эрх бүхий тендерт оролцогчдоос Хатанбулаг сумын “Эмнэлэгийн тоног төхөөрөмж” нийлүүлэх ажилд цахим тендер ирүүлэхийг урьж байна.

Тендер нь түүнийг нээсэн өдрөөс эхлэн 30 хоногийн дотор хүчинтэй байна.

Тендерт оролцогч нийлүүлсэн бараандаа 2 жилийн баталгаат хугацааг гаргаж ирүүлнэ.

Тендерийг 2020 оны 04-р сарын 15 ны өдрийн 14 цаг 00 минутаас өмнө Засаг даргын орлогчийн өрөө хаягаар ирүүлэх ба нээлтэд оролцох хүсэлтэй тендерт оролцогчдыг байлцуулан тендерийг 2020 оны 04-р сарын 15-ны өдрийн, 14 цаг 30 минутад нээнэ.

Сонирхсон этгээд тендерийн баримт бичиг болон бусад мэдээллийг www.tender.gov.mn хаягаар авч болно.

Хаяг:

Дорноговь аймаг Хатанбулаг сум ЗДТГ-р 203 тоот Засаг даргын орлогч

Холбоо барих утас 95514343

И:мэйл хаяг: zulchimedtseren@yahoo.com

ҮНИЙН САНАЛЫН МАЯГТ

Огноо

\Захиалагч байгууллагын нэр\ -ын дарга..... танаа

1.Бид \тендерт оролцогчийн нэр\ дор дурдсан \бараа, ажил, үйлчилгээ\ -г \саналын үнийг тоогоор болон үсгээр\ төгрөгөөр үнийн санал авах баримт бичгийн дагуу гүйцэтгэхээр санал болгож байна.

2.Энэ санал нь үнийн санал авах баримт бичигт засны дагуу тендер хүлээн авах эцсийн хугацаанаас хойш \тоо\ хоногийн хугацаанд хүчинтэй байх ба та энэ хугацаа дуусахаас өмнө түүнийг сонгох боломжтой.

3.Гэрээг албан ёсоор байгуулах хүртэл энэхүү тендер болон түүнийг шалгарсан тохиолдолд гэрээ байгуулах эрх олгох мэдэгдэл нь бидний хооронд хийгдсэн хэлцэл болно.

4.Бид гэрээний ерөнхий болон тусгай нөхцлийг хүлээн зөвшөөрч байна гэдгийг үүгээр батламжилж байна.

5.Бид гэрээг хэрэгжүүлэхдээ тухайн орон нутагт үйлдвэрлэгддэг бараа материал, үзүүлж буй үйлчилгээг заавал худалдан авахаа үүгээр мэдэгдэж байна.

\Бараа ажилүйлчилгээ\ - ний нэр төрөл	Тодорхойлолт	Тоо \хэмжээ ширхэг\	Нэгж үнэ	Нийт дүн	\НӨАТ болон бусад албан татвар\	Бүгд дүн
1	2	3	4	5	6	7
Тендерийн нийт үнэ						

Тендерт оролцогчийн нэр:

Эрх бүхий албан тушаалтны гарын үсэг, тамга

Албан тушаал, нэр

Хаяг

ТЕНДЕРТ ОРОЛЦОГЧДОД ӨГӨХ ЗААВАРЧИЛГАА

1.Эрх бүхий тендерт оролцогч

1.1.Сангийн сайдын 2013 оны 02 дугаар сарын 21 ны өдрийн 39 дугаар тушаалын 1-р хавсралтаар батлагдсан “Олон нийтийн оролцоотой худалдан авах ажиллагааны журам”-ын 1.4 дүгээр зүйлд заасан шаардлагыг хангасан хамтран ажиллах гэрээний үндсэн дээр байгуулагдсан Иргэдийн бүлэг байна.

2.Оролцогчийн чадвар

2.1.Тендерт оролцогч дор дурдсан чадварын шалгуур үзүүлэлтийг хангасан ба холбогдох мэдээллийг маягт 3.1, 3.2-ийн дагуу саналд ирүүлнэ.

а.Чадварын мэдээлэл

б.Туршлагын мэдээлэл

3.Тендерийн иж бүрдэл

3.1.Тендерт оролцогчдод өгсөн зааварчилгааны дагуу бэлтгэж ирүүлэх тендер нь дараах зүйлээс бүрдэнэ.

а.Үнийн санал

б.Чадварын мэдээлэл \маягт 3.1\ мэргэжилтэй ажилтан албан хаагчдийн мэдээлэл, мэргэжил, мэргэшлийн гэрчилгээний хуулбар

в.Туршлагын мэдээлэл \маягт 3.2\ ижил төстэй ажил гүйцэтгэсэн гэрээ актын хамт сүүлийн жилээр

г.Бараа нийлүүлэлтийн болон үйл ажиллагааны хуваарь

д.Төслийг хэрэгжүүлэх чадвартай талаарх харилцагч банкны тодорхойлолт

е.Татвар, нийгмийн даатгал, шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын өр төлбөргүй тухай тодорхойлолт

ё. Эм эмнэлэгийн хэрэгсэл худалдан борлуулах нийлүүлэх тусгай зөвшөөрөлтэй байх.

4.Үнийн санал

4.1.Тендерт оролцогчийн санал болгосон үнэ нь төгрөгөөр илэрхийлэгдсэн байх ба гэрээг хэрэгжүүлэх хугацаанд тогтмол байна.Үнийн тохируулгын нөхцөлтэйгээр ирсэн үнийн саналаас татгалзана.

4.2.Тендерт оролцогч үнийн хөнгөлөлтийг үнийн саналд тусган санал ирүүлж болно.

4.3.Тендерт оролцогч нь хүчин төгөлдөр мөрдөгдөж буй хууль тогтоомжийн дагуу энэ гэрээ болон бусад үндэслэлээр гүйцэтгэгчийн төлөх ёстой бүх татвар, хураамж, бусад төлбөрийг тендерийн нийт үнэд багтаасан байна.

5.Саналын хүчинтэй байх хугацаа

5.1.Санал нь түүнийг ирүүлсэн өдрөөс хойш 30 хоногийн хугацаанд хүчинтэй байна.Захиалагч онцгой нөхцөл байдал үүссэний улмаас үнийн саналын хүчинтэй байх хугацааг сунгахаар шийдвэрлэсэн тохиолдолд бүх оролцогчдод хандаж хүсэлт гаргана.

6.Алдааг залруулах

6.1.Захиалагч шаардлагад нийцсэн тендерийн арифметик алдааг шалгаж дараах байдлаар залруулна.

а.Тоо болон үсгээр илэрхийлэгдсэн дүн хоорондоо зөрсөн бол үсгээр илэрхийлэгдсэнийг зөв гэж үзнэ.

б.Үнийн хуваарь болон ажлын хуваарьт тусгагдсан үнийн нийлбэр тендерийн маягтад заасан нийт үнээс зөрвөл үнийн хуваарь, ажлын хуваарьт заасан үнийн нийлбэрийг үндэслэн тендерийн нийт үнийг залруулна.

6.2.Захиалагчийн залруулсан үнийн дүнг тендерт оролцогчийн зөвшөөрлөөр эцсийнх гэж үзнэ.Хэрэв тендерт оролцогч залруулсан дүнг хүлээн зөвшөөрөөгүй бол захиалагч түүний тендерээс татгалзана.

7.Үнийн саналын битүүмжлэл ба бичиглэл:

Оролцогч нь үнийн саналаа битүүмжлэн дугтуйнд хийх ба дугтуйны гадна талд “Эх хувь”гэсэн бичиглэл хийж тэдгээрийг дахин нэг давхар дугтуйнд хийж битүүмжлэн захиалагчид ирүүлнэ.Доторх болон гаднах дугтуйнуудад захиалагчийн нэр, оролцогчийн нэр, тендер нээх хугацаанаас өмнө нээж үл болно гэсэн бичиглэл хийнэ.

8.Санал болгосон үнэ түүнийг үнэлэх

8.1.Захиалагч хамгийн бага харьцуулах үнэтэй тендерийг “хамгийн сайн” үнэлэгдсэн тендер гэж үзэж тендерт оролцогчид гэрээ байгуулах эрхийг олгоно.

9.Гэрээ байгуулах эрх олгох тухай мэдэгдэл

9.1.Энэ мэдэгдэлд гэрээнд заасны дагуу хийгдэх ажилд төлөх мөнгөн дүн буюу гэрээний үнийг заана.Гэрээний үнэ нь залруулга болон үнийн хөнгөлөлтийг тооцсон тендерийн үнэ байна.

9.2.Бусад оролцогчдод тэдгээрийн шалгараагүй үндэслэлийг тодорхой тайлбарласан мэдэгдлийг нэгэн зэрэг хүргүүлнэ.

Жич: Чадварын мэдээлэл маягт-3.1

Ажлын туршлагын ерөнхий мэдээлэл маягт-3.2

Ажиллах хүчний чадавхи маягт-3.3

Ажиллах хүчний туршлагын ерөнхий мэдээлэл маягт-3.3А зэрэг маягтыг

Төрийн худалдан авах ажиллагааны **tender.gov.mn** сайтын хууль эрх зүй хэсгийн **тендерийн жишиг бичиг баримт** хэсгээс татан авна уу.

ТЕХНИКИЙН ТОДОРХОЙЛОЛТ

Нэг.Ажлын тодорхойлолт: Хатанбулаг сумын 5 дугаар багт “Эмнэлэгийн тоног төхөөрөмж” бараа нийлүүлэх.

1. ТАРИУРЫН ШАХУУРГА:

Техник үзүүлэлт:

Түвшингийн хязгаар

50 мл тариур: 0.1 ~ 1800 мл/цаг (0.1 ~ 999.9 мл/цаг алхам: 0.1 мл/цаг)

- 30 мл тариур: 0.1 ~ 900 мл/цаг (1000 ~ 1800 мл/цаг алхам: 0.1 мл/цаг)

- 20 мл тариур: 0.1 ~ 600 мл/цаг

- 10 мл тариур: 0.1 ~ 300 мл/цаг

- 5 мл тариур: 0.1 ~ 150 мл/цаг

- Түвшний хязгаар:

~ 1999,9 мл (алхам: 0.1ml)

- Хуримтлагдсан хэмжээ:

9999,9 мл (алхам: 0.1 мл)

- Нарийвчлал:

+_-2%

KVO хязгаар:

~ 5 мл/цаг (тохируулж, алхам: 0.1 мл/цаг)

- Гал хамгаалагч:

F1AL / 250 В ("F" хурдан зааж, хурдан таслана)

2 ширхэг (шахуурга дотор суулгагдсан)

- Цахилгаан хангамж:

110-220 В, 50 Гц, дахин цэнэглэгддэг 11.1 В, багтаамж 2000 мА

10 цаг цэнэглэнэ. /5 мл/ цаг (GB9706.27) дунджаар 4 цаг ажиллана./

- Цээрлэх түвшин:

50 мл-ийн тариур: 1800 мл / ц (Bolus үнэ: 1200 мл / цаг)

30 мл-ийн тариур: 900 мл / ц (Bolus хэмжээ: 600 мл / цаг)

20 мл-ийн тариур: 600 мл / ц (Bolus хэмжээ: 400 мл / цаг)

10 мл-ийн тариур: 300 мл / ц (Bolus хэмжээ: 200 мл / цаг)

5 мл-ийн тариур: 150 мл / ц (Bolus хэмжээ: 100 мл / цаг)

- Дохиолол:

Шингэний хэмжээний дохиолол.

Дуусах дохиолол

Тунгын тарилгын дууссан дохиолол

Бөглөрлийн дохиолол

Тариур унтрах үеийн дохиолол

Тариур сарниагүй үеийн дохиолол

Зай дуусах үеийн дохиолол

Тэжээлгүй болох үеийн дохиолол

- Бөглөрөл:

Бөглөрөл нь 3-н түвшинтэй: өндөр, дунд, нам

- Ажлын орчин

Температур: + 5 ~ + 40 ° C

Humidity: 20% ~ 90%

- Хадгалах орчин

Температур: -30 ° C ~ + 50 ° C

Чийглэг: ≤ 95%

- Агаар даралт:

860 hPa ~ 1060 hPa

- Аюулгүй ангилал:

Нэгдгээр төрлийн CF төхөөрөмж, дотоод зай, тасалууртай, Ачаалалтай үргэлжилэх

- Хэмжээ: 282 мм (урт) * 210 мм (өргөн) * 148 мм (өндөр)

Жин: 2.2 кг

2.ХАГАС АВТОМАТ БИОХИМИЙН АНАЛИЗАТОР:

Техникийн тодорхойлолтууд: Үзүүлэлтүүд: -ALT, AST, ALP, ACP, GGT, α-HBDH, LDH, CK, AMY.TG.TC, HDL-C, UA, UREA, Cr, Glu, TP, Alb, T-bil, D-Bil, TBA, NH4+ , HCO3-, Ca, Mg, Cl , Na, K, apoAI , apoB, Lp (a), C3, C4 , IgG, IgA, IgM, HbA1c, спирт, амфетамин, барбитурат, г.м.

Судалгаа шинжилгээний арга барил -Уусгал, шугаман болон шугаман бус тохируулга.

Гэрэлийн эх үүсвэр

-Вольфрамын галоген Lamp 6V/10W

Долгионы урт, хязгаарлалтын үзүүлэлт

-Бүхэлд нь бүрхсэн хамгийн бага хэмжээний 8 шүүлтүүртэй: 340nm , 405nm , 450nm , 510nm , 546nm , 578nm ,630nm and 670nm . зурвасын өргөн< 8nm

Фотометрийн хязгаарлалт

-0~3.5 ABS, тэнцвэржилт :< 0 . 005A / 20min @ 340nm

Фловселл -Цагаан чулуун цонхтой цэвэр төмөр, Авианы хэмжигдэхүүн нь 32 μL, Харагдах байдал 10 mm Програмчлагдсан авиа гаргах нь 200~9000 μL

Дотоод -Мэдрэгчтэй дэлгэцтэй мэдрэгчтэй үзэг, USB гээр гар болон товчлуур холбож болно.

Температурын хэмжээ -Тасалгааны температур 25°C , 30 °C and 37°C

Хадгалалт -3000 гаруй нийлбэр жишээтэй ,1000 гаруй QC жишээтэй

Хувилагч -Цахилгаан хувилагч, HP гийн тусламжтай

Үйл ажиллагаа явуулах орчин -Температур 15°C~30°C, чийг 35%~85%

Цахилгааны тавигдах шаардлага -Цахилгаан нийлүүлэлт : AC 100-240V, 50 / 60Hz

Хэмжээ -430mm x 360mm x 170mm (L x W x H)

Жин -6.8 Kg-аас багагүй

Хагас автомат цусны биохимийн анализатор

- Кинетикийн, уусмалын

- Долгионы урт, хязгаарлалт 340 оос 670 nm

- 7 . 0 " TFT мэдрэгчтэй дэлгэц болон нүдэнд харагдахаар товчлуурт самбар

- USB холбогдох гар болон товчлуур

- 200 гаас дээш тест программчлж болно.

- Тестийн загвар нь: фловселл болон куветте

- Ашиглахад хялбар харилцах хэсэг

- Эрчим хүчний алдааг хамгаалсан

- Нийтлэг эрчим хүчний нийлүүлэлттэй

Хагас автомат химийн анализатор -Харилцааны шууд программ хангамжтай, асахад маш хялбар, өргөн LCD мэдрэгчтэй дэлгэцтэй, хэрэглэхэд хялбар, 2 USB оролттой keyboard, mouse and printer.

3.НЯРАЙН ДУЛААЦУУЛАХ ШИРЭЭ ЗАГВАР

- Үйл ажиллагааны орчин
- Ашиглалтын температур $+ 18^{\circ}\text{C} \sim + 30^{\circ}\text{C}$
- Үйл ажиллагааны орчны харьцангуй чийгшил $30^{\circ}\text{C} \sim 75\%$
- Ашиглалтын орчин дахь агаарын урсгалын хурд $< 0.3\text{ м / с}$
- Эрчим хүчний шаардлага $\leq 1000\text{VA}$
- Температурыг тохируулах хүрээ $25^{\circ}\text{C} \sim 37^{\circ}\text{C}$ байна
- Температурын мэдрэгчийн нарийвчлал $\leq 0.3^{\circ}\text{C}$
- Матрасын температурын жигд байдал $\leq 2.0^{\circ}\text{C}$
- Халаах цаг ≤ 45 мин
- Дулааны гаралтын хэмжээг $0 \sim 100\%$ -ийн
- Матрас тавиурын хэмжээ $68\text{см} \times 54\text{см}$
- Матрасны хазайлтыг тохируулах хүрээ $0 \sim \pm 10$
- Матрас тавиурын хамгийн их ачаалал 10кг
- IV зогсоолын хамгийн их ачаалал 2кг
- Тавиурын хамгийн их ачаалал 2кг
- Рентген кассет Тийм
- RS-232 холбогч N / A
- Радиан туяаны нэгж 81см
- Хэт улаан туяаны долгионы урт $1 \sim 3\mu\text{м}$
- APGAR таймер N / A
- Тусгай дохиололтой
- Цахилгааны доголдлын дохиолол Тиймээ
- Мэдрэгч дутагдлын дохиолол:Тийм
- Температурын хэлбэлзлийн дохиолол $\pm 1.0^{\circ}\text{C}$
- Системийн алдааны дохио N / A
- Бага даралттай сорох N / A
- Даралтыг тохируулах хүрээ N / A
- Дуу чимээний түвшин N / A
- Цагаан гэрэл эмчилгээний гэрэл N / A
- 7л хүчил төрөгчийн цилиндр (хүчилтөрөгчийн манометр ба хүчилтөрөгчийн урсгал хэмжигч бүхий)
- Нярайн сэхээн амьдруулах баг N / A

IRV 1000 түүнтэй дүйцхүйц



ТЕХНИКИЙН ТОДОРХОЙЛОЛТ БОЛОВСРУУЛСАН:
ҮНЭЛГЭЭНИЙ ХОРООНЫ ДАРГА
НАРИЙН БИЧИГ
ГИШҮҮД

Д.БУЯНЦЭЦЭГ
Х.МӨНХЖАРГАЛ
Б.АРИУНЖАРГАЛ
Н.БОЛОРЦЭЦЭГ
П.САЙНБУЯН

ГЭРЭЭНИЙ ЕРӨНХИЙ НӨХЦӨЛ

1. **Гүйцэтгэх бараа, ажил үйлчилгээ**
 - 1.1. Гүйцэтгэгч бараа, ажил, үйлчилгээг гэрээний тусгай нөхцөлд заасны дагуу хийж гүйцэтгэнэ.
2. **Ажлын хуваарь**
 - 2.1. Гүйцэтгэгч гэрээний тусгай нөхцөл буюу техникийн тодорхойлолт, ажлын даалгаварт заасан хуваарийг чанд мөрдөж ажиллана.
3. **Оюуны өмчийн эрх**
 - 3.1. Гэрээнд заагдсан бараа, ажил үйлчилгээг худалдан авах ажиллагаанд оюуны өмчийн эрхийг захиалагч болон нийлүүлэгч зөрчсөн хэмээн гуравдагч этгээдийн нэхэмжилсэн гомдлыг нийлүүлэгч барагдуулж, холбогдох зардлыг хариуцна.
4. **Гэрээнд өөрчлөлт оруулах**
 - 4.1. Гэрээний дагуу худалдан авах бараа, ажил, үйлчилгээний нэр төрөл үзүүлэлтийг өөрчлөхгүй.
5. **Гүйцэтгэлийн хянагч**
 - 5.1. Гэрээнд тусгайлан заагаагүй бол гэрээтэй холбогдсон аливаа асуудлыг шийдвэрлэх үүрэг бүхий захиалагчийг төлөөлөн гүйцэтгэлийн хянагч ажиллана.
6. **Төлбөр**
 - 6.1. Захиалагч төлбөрийг нэхэмжлэх хүлээн авснаас хойш 7 хоногийн дотор шуурхай хийнэ.
7. **Алданги оногдуулах**
 - 7.1. Захиалагч нийлүүлэгчийн хугацаа хоцорч нийлүүлсэн бараа, гүйцэтгэсэн ажил, үйлчилгээний гэрээний үнийн ГТН-д заасан хувьтай тэнцэх алданги оногдуулж, гэрээний үнийг тэр хэмжээгээр бууруулна. Алдангийн нийт дүн ГТН-д заасан дээд хэмжээнээс хэтрэхгүй.
8. **Үүргээ биелүүлээгүйгээс гэрээг цуцлах**
 - 8.1. Гүйцэтгэгч гэрээний үүргээ биелүүлээгүй тохиолдолд захиалагч гэрээг цуцалж, захиалагчид учирсан аливаа хохирлыг нийлүүлэгч барагдуулна.
9. **Маргааныг шийдвэрлэх**
 - 9.1. Талууд гэрээний үүргийн биелэлттэй холбогдсон асуудлаар тохиролцоонд хүрч чадахгүй бол зохих тал шүүхэд нэхэмжлэл гаргана.
10. **Бусад нөхцөл**
 - 10.1. Үйлдвэрлэгчийн тухайн бараанд олгодог баталгаат засварын хугацаатай байна.
 - 10.2. Гэрээнд хэрэглэсэн үнэ болон бусад худалдааны нэр томъёог Инкотермс буюу Парис хот дахь Олон улсын худалдааны танхимаас боловсруулж гаргасан сүүлийн хувилбарт тодорхойлсон утгаар ойлгоно.
 - 10.3. Гүйцэтгэгч ажлын талбай дээрх бүх үйл ажиллагааны аюулгүй байдлыг хангана.

Б. ХУГАЦААНЫ БОЛОН ЧАНАРЫН ХЯНАЛТ

11. **Үйл ажиллагааны хөтөлбөр**
 - 11.1. Гүйцэтгэгч нь бараа нийлүүлэх, ажил гүйцэтгэх, үйлчилгээ үзүүлэхэд шаардлагатай бүх үйл ажиллагааны ерөнхий аргачлал, зохион байгуулалт, дэс дараалал, хугацаа болон бусад шаардлагатай мэдээллийг тусгасан

- үйл ажиллагааны хөтөлбөрийг боловсруулж, гэрээний тусгай нөхцөлд заасан хугацаанд гүйцэтгэлийн хянагчид хүргүүлж батлуулна.
- 12.Зөрчил гологдол илрүүлэх** 12.1.Гүйцэтгэлийн хянагч гүйцэтгэгчийн үйл ажиллагааг шалгаж, илэрсэн зөрчил, гологдлын талаар мэдэгдэнэ.Энэхүү шалгалт нь гүйцэтгэгчийн үүрэг хариуцлагыг хөндөхгүй.Гүйцэтгэлийн хянагч нь гүйцэтгэж буй аливаа ажилд зөрчил гологдол хайх, уг ажлын далд хэсгийг нээж шалгалт, туршилт явуулах эрхтэй.
- 13.Зөрчил гологдол арилгах** 13.1.Гүйцэтгэлийн хянагч гэрээний тусгай нөхцөлд заасан чанарын баталгаат хугацаа дуусахаас өмнө зөрчил, гологдол арилгах тухай мэдэгдлийг гүйцэтгэгчид өгнө.Чанарын баталгаат хугацааг зөрчил гологдлыг арилгаж дуусах хүртэл сунгана.
- 13.2.Зөрчил гологдол арилгах тухай мэдэгдэл өгсөн тухай бүр гүйцэтгэгч уг зөрчил гологдлыг гүйцэтгэлийн хянагчийн мэдэгдэлд заасан хугацаанд багтааж өөрийн зардлаар арилгана.
- 14.Зөрчил гологдол арилгахгүй байх** 14.1.Хэрэв гүйцэтгэгч зөрчил, гологдлыг гүйцэтгэлийн хянагчийн мэдэгдэлд заасан хугацаанд багтааж арилгаагүй бол гүйцэтгэлийн хянагч зөрчил, гологдол арилгахад шаардагдах зардлыг тооцож гүйцэтгэгчээс гаргуулна.
- Г.ГЭРЭЭГ ДУУСГАХ**
- 15.Гэрээний үүрэг дуусгавар болох** 15.1.Гүйцэтгэгч нь гэрээний үүргээ хэрэгжүүлж дууссан тухай мэдэгдэл гаргах хүсэлтийг гүйцэтгэлийн хянагчид хүргүүлэх бөгөөд гүйцэтгэлийн хянагч ажил дууссан гэж үзвэл уг мэдэгдлийг гаргана.

ГЭРЭЭНИЙ ТУСГАЙ НӨХЦӨЛ

1.1 Гэрээний нэр болон бүртгэлийн дугаар: Хатанбулаг сум ЭМТ-д “Эмнэлэгийн тоног төхөөрөмж” нийлүүлэх ХБ- ОНО-2020/05

Бараа, ажил, үйлчилгээ нь \товч тодорхойлолт, түүний дотор төслийн хүрээнд бусад гэрээтэй холбогдох байдал\-аас бүрдэнэ.

Гэрээний үүрэг хэрэгжүүлэх газар: Хатанбулаг сумын 5-р багт

Гэрээ хэрэгжүүлж эхлэхээр төлөвлөсөн өдөр 2020-04-20

Гэрээг дуусгахаар төлөвлөсөн өдөр 2020-05-20

5.1 Гүйцэтгэгч гэрээ байгуулах эрх олгох тухай мэдэгдлийг хүлээн авснаас хойш 7 хоногийн дотор тодотгосон ажлын хөтөлбөрийг гаргаж гүйцэтгэлийн хянагчаар батлуулна.

6.1 Гүйцэтгэгч дараах баримт бичгийг захиалагчид бүрдүүлж өгнө.

Ажлын нэр, тоо ширхэг, нэгж болон нийт үнийг заасан нэхэмжлэхийн хувь

Гэрээний төлбөрийг гэрээ байгуулж ажлыг эхлүүлсэнээр 30% хэрэгжүүлж дууссаны дараа ажил хүлээж авах комисст хүлээлгэн өгч акт үйлдэн гүйцэтгэлийн тайлан ирүүлсэнээр үлдэгдэл 70%-ийн санхүүжилтийг тус тус олгоно.

7.1 Алданги ногдуулах хэмжээ хугацаа хэтрүүлсэн хоног тутам гүйцэтгээгүй үүргийн үнийн дүнгийн 0,5 хувь байна.

Нийт ногдуулах алдангийн хэмжээ нь гэрээний үнийн дүнгийн 10 хүртэл хувь байна.

